

“Жэтфинанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оныр сарын
.....-ны өдрийн..... тоот тогтоолын Хавсралт No. 1



“ЖЭТФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн бүрэн эрх, түүний гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, бүрэлдэхүүн, зөвлөлийн дарга, гишүүд /цаашид дарга, гишүүд гэх/-ийн бүрэн эрхийн хугацаа, нэр дэвшүүлэх, сонгох журам, зөвлөлийн үйл ажиллагааны журам болон зөвлөлөөс Банк бус санхүүгийн байгууллагын бусад эрх бүхий этгээд, зөвлөлийн хороодтой харилцах харилцаа, гишүүний хүлээх хариуцлага, мөн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө гишүүнийг чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. “Жэтфинанс ББСБ” ХХК /цаашид ББСБ гэх/ болон гишүүн хоорондын харилцааг Иргэний хуульд заасан гэрээгээр зохицуулах ба тус гэрээнд банк бус санхүүгийн байгууллагын нэрийн өмнөөс хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид ХЭХ гэх/-аас итгэмжлэгдсэн томилодсон этгээд гарын үсэг зурна.

Хоёрдугаар зүйл. ТУЗ-ийн бүрэн эрх

- 2.1. ТУЗ-аас хууль болон банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн дагуу ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас бусад ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.2. ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
 - 2.2.1. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах.
 - 2.2.2. Компанид хадгалж байвал зохих нэмэлт баримт бичгийн жагсаалт гаргах.
 - 2.2.3. Зөвшөөрөл бүхий үйлчилгээг үзүүлэхэд бодлого чиглэл гаргах.
- 2.3. ХЭХ-д бэлтгэх, хурлыг зохион байгуулахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараахь үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
 - 2.3.1. Хэрэв саналын хуудсаар урьдчилан санал авах тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурал болох огноо, газар, эхлэх цаг, бөглөсөн саналын хуудсаа илгээх шуудангийн хаягийг тодорхойлох, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг тодорхойлох.
 - 2.3.2. ХЭХ-ын оролцогчдын нэрийн жагсаалтыг гаргах, бүртгэлийн өдрийг тодорхойлох
 - 2.3.3. ХЭХ-ын хэлэлцэх асуудлуудыг батлах, хувьцаа эзэмшигч /цаашид ХЭ гэх/-гчдийн саналыг хурлын хэлэлцэх асуудалд тусгах
 - 2.3.4. ХЭХ-д бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцах болон мэдээлэл, материалын жагсаалт гаргах, тухайн мэдээлэлтэй танилцах боломжоор хангах.
 - 2.3.5. Хэрэв саналын хуудсаар санал авах бол саналын хуудсын маягт, агуулгыг батлах

- 2.3.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /ХЭЭХ/ болон ХЭ-ийн ээлжит бус хурлыг зарлах /ХЭЭБХ/
- 2.3.7. Хувьцаа эзэмшигч тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр санал болгосон эсэхээс үл хамааран өөр бусад асуудлыг ХЭХ-ын хэлэлцэх асуудлуудад тусгах.
- 2.4. ТУЗ-ын үйл ажиллагааны журам батлах.
- 2.5. Ногдол ашгийн төлбөрийн хэмжээг тогтоож, зохион байгуулах.
- 2.6. Хуульд заасан тохиолдолд их хэмжээний хэлцэлийг батлах.
- 2.7. ББСБ-ын гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, хянахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараахь үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
 - 2.7.1. Гүйцэтгэх удирдлагын багийн хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт тавих
 - 2.7.2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх
 - 2.7.3. Хууль тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх.
 - 2.7.4. ББСБ-ын эрх ашгийг хувийн болон өөрийг нь сонгосон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавихгүй байх
 - 2.7.5. Нууцаар ашиг хүртэхгүй байх
 - 2.7.6. Сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдэгддэг байх
 - 2.7.7. ББСБ-ын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх.

Гуравдугаар зүйл. ТУЗ-ийн бүрэлдэхүүн

- 3.1. ТУЗ нь 5 хүртэл гишүүнээс бүрдэнэ.
- 3.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь хувь хүн байж болно. Хувьцаа эзэмшигч биш этгээдийг зөвлөлийн гишүүнээр сонгож болно.
- 3.3. ББСБ-ын ТУЗ-д сонгогдсон хүмүүс хэдэн ч удаа дахин сонгогдох боломжтой.
- 3.4. Гишүүд нь 3-аас илүү тооны компани, ББСБ-д нэгэн зэрэг удирдах алба хашихгүй.
- 3.5. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн, засгийн газар, орон нутгийн удирдлагын эсрэг захиргааны зөрчил гаргасан этгээд, мөн бизнес, санхүү, татвар, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргасан этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.
- 3.6. ТУЗ-ийн нарийн бичгийн албан тушаалд гишүүнээр ажиллаж байгаа хүнийг томилж болно.
- 3.7. ТУЗ-ийг ТУЗ-ийн дарга удирдана.
- 3.8. ББСБ-ийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс ТУЗ-д ажиллах гишүүдийн тоо нь ТУЗ-ын гишүүдийн 2/5-ээс илүү байж болохгүй
- 3.9. Нийт гишүүдийн нэг нь хараат бус гишүүн байна.
- 3.10. ББСБ-ын ТУЗ-д гурван жилийн турш ажилласан хараат бус гишүүнийг хараат бусад тооцохгүй.

Дөрөвдүгээр зүйл. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа

- 4.1. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа дараагийн ХЭХ хүртэл үргэлжилнэ.

- 4.2 Өмнөх ТУЗ-ийн бүрэн эрх дараа жилийн ХЭ-дийн ээлжит хурал эхлэхэд дуусгавар болох ба ТУЗ-ийн шинэ гишүүдийг дээрх хурал дээр сонгоно.
- 4.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эрхтэй.
- 4.4 Хэрэв гишүүн удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан бол ТУЗ-аас орлох хүнийг дараагийн ХЭХ хүртэл түр томилж болно.

Тавдугаар зүйл. Нэр дэвшүүлэх

- 5.1 Хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд тодорхой этгээдийг нэр дэвшүүлэх эрхтэй.

Зургадугаар зүйл. Гишүүнээр сонгох ба чөлөөлөх

- 6.1 ХЭХ-аас ТУЗ-ийн бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Ингэхдээ ХЭХ-аас нийт гишүүдтэй холбогдуулан дээрх шийдвэрийг гаргаж болно.
- 6.2 ТУЗ-ийн аль нэг гишүүн чөлөөлөгдөхийг хүсвэл гишүүний зүгээс ТУЗ-д чөлөөлөгдөх хүсэлтээ 30 хоногоос өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 6.3 Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн 70-иас илүү хувь нь ажиллах боломжгүй бол ТУЗ-аас шинэ ТУЗ байгуулах талаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах шийдвэр гаргана.
- 6.4 ТУЗ-ийн гишүүд хуралдаж, Аудитын хороо, Эрсдлийн удирдлагын хороо, Урамшууллын хороог байгуулж, гишүүдээ сонгоно.

Долдугаар зүйл. ТУЗ-ийн дарга

- 7.1 Хувьцаа эзэмшигч эсвэл ТУЗ-ийн гишүүд өөрсдийн дундаас ТУЗ-ийн даргыг сонгож болно.
- 7.2 ББСБ-ийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнээр ажиллаж байгаа нэр дэвшигчийг ТУЗ-ын даргаар сонгохгүй.
- 7.3 ТУЗ-ийн дарга дараахь үйл ажиллагааг хариуцна.
 - 7.3.1 ТУЗ-ийн ажлыг зохион байгуулах, нийт гишүүдийг санал бодлоо чөлөөтэй солилцох нөхцлөөр хангах, хэлэлцэх асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг явуулах
 - 7.3.2 ТУЗ-ийн уулзалтын хуваарь гаргаж, зохион байгуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг бэлтгэх, гишүүдийн санал авах хуудаст үндэслэн санал хураалт явуулах.
 - 7.3.3 Хурлын тэмдэглэл хөтлүүлэх, тэмдэглэлд гарын үсэг зурах.
 - 7.3.4 Гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшигчтэй холбогдуулан тухайн нэр дэвшигчид эрүүгийн гэмт хэрэг шийтгүүлсэн эсвэл захиргааны шийтгэл оногдуулсан эсэх талаар мэдээлэл авах хүсэлт гаргах хасах эсэх
 - 7.3.5 Гүйцэтгэх удирдлага, Дотоод аудитын нэгж, хороодоос ирүүлсэн хангалттай материалд үндэслэн зохистой хэлэлцүүлэг, санал хураалт явуулснаар ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудаар үр дүнтэй шийдвэр гаргах
 - 7.3.6 Хурлаас 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдийг хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээллээр хангах.

7.3.7 Гүйцэтгэх захирал болон бусад удирдах ажилтнуудтай байнгын харилцаа холбоотой ажиллах.

Наймдугаар зүйл. ТУЗ-ийн хурал

8.1 Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга өөрийн санаачлагаар хуралдуулах ба дараахь албан тушаалтны саналын дагуу хуралдуулна.

8.1.1 ТУЗ-ийн гишүүн

8.1.2 Хувьцаа эзэмшигч

8.1.3 Гүйцэтгэх захирал

8.2 ТУЗ-ийн хурал болох огноо, эхлэх цаг, хэлэлцэх асуудлын талаарх мэдэгдэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой болон хуралд бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг ТУЗ-ийн гишүүн бүрт болон санал гаргасан этгээдэд бичгээр, эсвэл скандаж имэйл хаягаар нь хурал болохоос ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэнэ.

8.3 ТУЗ-ийн хурлыг хүчинтэй болгох гишүүдийн хамгийн бага ирц нийт гишүүдийн 50%-аас багагүй байна.

8.4 ТУЗ-ийн гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн нэг гишүүнийн саналын эрхийг нөгөө гишүүнд шилжүүлэх, саналын эрхийг өөр хүнд итгэмжлэлээр дамуужлах үйл ажиллагааг зөвшөөрөхгүй.

8.5 Сонирхолын зөрчилтэй хэлцлийг батлах шийдвэрийг хуульд заасан хоорондоо ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100%-ийн саналаар гаргана. Нийт гишүүд тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй бол ХЭХ-аас дээрх хэлцлийг батлах шийдвэр гаргана.

8.6 ТУЗ-ийн шийдвэрүүдийг хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналын дагуу гаргана.

Есдүгээр зүйл. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр

9.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөнө.

9.2 ТУЗ-ийн хурлын тэмдэглэл дээр тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцан дарга гарын үсэг зурна.

9.3 Гарч буй шийдвэрүүд ТУЗ-ийн тогтоол хэлбэрээр гарах бөгөөд дарга гарын үсэг зурж тамга дарагдсанаар хүчинтэй болно.

9.4 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ББСБ-ын Хувьцаа эзэмшигч танилцаж болно.

9.5 ББСБ нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, материалыг ББСБ-ын байранд хадгална.

Аравдугаар зүйл. ТУЗ-ийн гишүүдийн үүрэг, хариуцлага

10.1 Гишүүд эрх, үүргээ дараахь байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

10.1.1 Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга, хандаж, ББСБ болон ХЭ-дийн эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэн анхааралтай, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах.

10.1.2 Зарласан хурлуудад оролцох

10.1.3 Тодорхой бус, ойлгомжгүй асуудлуудын талаар тодруулга хийж, асуулт тавих

10.1.4 ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй болсон шалтгаанаа ТУЗ-д мэдэгдэнэ.

- 10.1.5 ТУЗ-ийн гишүүнээр ажиллах үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон ББСБ-ээс халагдсаны дараа 3 жилийн турш дээрх мэдээллийг ашиглах ёсгүй хүмүүст задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ажиллахгүй.
- 10.2 Хараат бус гишүүн хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв тийм нөхцөл байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 10.3 Энэхүү журамд заасны дагуу гишүүд өөрсдийн гаргасан алдаа, албан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн ББСБ-д учирсан хохиролд хариуцлага хүлээнэ.
- 10.4 Энэхүү журмын зүйл заалтуудыг зөрчиж шийдвэр гаргасан гишүүд хамтдаа хариуцлага хүлээх ба хохирлыг хувь тэнцүүлэн нөхөн төлнө.

Арваннэгдүгээр зүйл. Ажлын хөлс

- 11.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн гишүүдэд ТУЗ-ийн гишүүний үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан гарсан зардлын нөхөн төлбөр, мөн ажлын хөлсийг ажиллах хугацаанд нь Хувьцаа эзэмшигчтэй тохиролцон гэрээ байгуулан олгож болно.

“ЖЭТФИНАНС ББСБ” ХХК

